



ОРЧУУЛГАД НЭМЭХ АРГЫГ ХЭРЭГЛЭСЭН БАЙДАЛ

(“Genghis khan and the making of the modern world” номын монголчуудын амьдрах орчин болон байгалийн байдлыг илэрхийлсэн өгүүлбэрүүдийн жишээн дээр)

Д. Сувданчулуун¹⁸

Д. Цэеэрэгзэн¹⁹

Abstract: This study aims to elucidate the utilization of addition techniques in literary translation and the underlying rationales driving their usage. The research focuses on sentences related to the living environment of the Mongolians and natural state depicted in the books "Genghis Khan and the Making of the Modern World" by Jack Weatherford and "Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Эзэн Чингис хаан" translated by G. Ganbold. Employing both qualitative and quantitative research methods, the investigation draws upon Rodica Dimitriu's (2004) framework, which advocates for considering linguistic, pragmatic, cultural, and ideological adjustments in translation. The findings of this research highlight that addition techniques are commonly used, particularly in literary translation, in order to accommodate the linguistic and stylistic preferences, as well as cultural disparities of the target language readers.

Түлхүүр үг: орчуулга, нэмэлт, прагматик, тохируулан буулгах, уран хэллэг

Удиртгал

Бид орчуулга хийх явцдаа аль болох эх бичвэрт үнэнч байхыг хичээдэг ч зарим үед зорилтот хэлний уншигчдын хэл яриа, соёл, сэтгэхүйд нь тохируулан буулгахын тулд орчуулгад янз бүрийн хувиргалууд хийдэг. Эдгээрийн нэг бол нэмэх арга буюу нэмэлт юм. Нэмэлт гэдэг нь эх хэлний утгыг тодорхой илэрхийлэхийн тулд үг, холбоо үг, илэрхийлэл, мөн өгүүлбэр нэмж оруулахыг хэлнэ. Тухайлбал, профессор Юань Яао “англи болон хятад хэлний дүрмүүд харилцан адилгүй улмаас зарим тохиолдолд нэмэлт оруулдаг. Тухайлбал, англиас хятад руу хөрвүүлэхэд олон тооны хэлбэр, үйл үгийн цагийг тодорхой болгох тохиолдлуудад мөн хятад хэлэнд байдаггүй англи хэлний төлөөний үг, угтвар үг, ялгац гишүүн зэргийг илэрхийлэхийн тулд үг нэмэх хэрэгтэй болдог” хэмээн дурджээ.

Тус судалгааг хийх явцад англи, монгол хэлний дүрмийн ялгаанаас үүдсэн нэмэлтүүд төдийлөн анзаарагдаагүй ч хоршоо үг хэллэг болгох, уран дүрслэл оруулан тэмдэг нэр, дайвар үгс нэмэх зэргээр уг зохиолыг аль болох уншигчдад уран яруу хийгээд өөриймсүүлэн хүргэхэд зонхилох нэмэлтүүд хийгдсэн байна.

Онолын хэсэг

Южин Найда “Toward a Science of Translating: with special reference to principles and procedures involved in bible translating” (1964:226-231) номдоо “эх хэлний бичвэрийг хүлээн авагч хэлний уншигчдад хэл болон соёлын хувьд тохируулан буулгахын тулд орчуулагч нэмэлт, хасалт болон өөрчлөлт гэсэн үндсэн 3-н аргыг хэрэглэдэг” гэж үзсэн.

¹⁸ ХУИС, Хэл, Соёлын Сургуулийн хэл шинжлэлийн докторант

¹⁹ ХУИС, Доктор (Ph.D.), профессор

Мөн тэрээр энэ номдоо нэмэх аргын талаар “Орчуулгад хууль зөрчилгүйгээр оруулж болох олон төрлийн нэмэлтүүдээс хамгийн түгээмэл бөгөөд чухал нь:

1. Хэлэлгүй орхигддог үгсийг нөхөж бичих (ellipsis) /I want to go but I can't./
2. Хоёрдмол утга юм уу буруу ойлголт өгөхгүйн тулд нарийвчлан тодруулах (obligatory specification)
3. Дүрмийн ялгаанаас үүдэлтэй нэмэлтүүд
4. Далдаар илэрхийлснийг ил буулгах
5. Риторик асуултуудад заавал хариулах шаардлага
6. Бусдаас ялгахын тулд нэмэлт үгс оруулах
7. Холбох шаардлагаар нэмэх
8. Эх бичвэрийн хэлэнд байдаггүй зорилтот хэлний хэсгүүд
9. Заавал хамт хэлэгддэг үгс

Эдгээр нэмэлтүүдийн ихэнх нь бүтцийн өөрчлөлтийн нэг хэсэг бөгөөд тиймийн учир нэг техникийг нөгөөгөөс нь хатуу тусгаарлах боломжгүй юм” гэжээ.

Питер Ньюмарк “Textbook of Translation” (1988:91-92) номдоо, “Орчуулагчийн өөрийн хувилбарт нэмж оруулах шаардлагатай нэмэлт мэдээлэл нь ихэвчлэн

- соёлын (ЭХ болон ЗХ соёлын ялгааг харгалзан үзэх),
- техникийн (сэдэвтэй холбоотой) эсвэл
- хэл шинжлэлийн (үгсийн буруу хэрэглээг тайлбарлах) байх ба эх хувилбараас ялгаатай нь энэ нь түүний уншигчдын шаардлагаас хамаарна” хэмээн тэмдэглэжээ.

“Тиймээс “you can pay for ceramic tiles under a convenient credit purchase scheme” буюу “та керамик хавтангийн төлбөрийг зээлээр худалдан авах тохиромжтой схемийн дагуу төлж болно” гэсэн өгүүлбэрийн “scheme” сүүлийн нэр томъёог илүү нарийвчлалтайгаар “long-term payment facility” буюу “урт хугацааны төлбөрийн хэрэгсэл” хэмээн орчуулж болно” гэжээ.” Мөн тэрээр, “Орчуулгын нэмэлт мэдээлэл нь янз бүрийн хэлбэртэй байж болно. Үүнд:

1-рт, текстийн дотор:

- Орчуулагдаж буй үгийн өөр хувилбараар
- Тодотгол гишүүн өгүүлбэрээр
- Тодотгосон нэр үгээр (As a noun in apposition)
- Үйл үгийн хувилбаруудаар
- Хашилтад (ихэвчлэн шууд үгчилж орчуулсан үгэнд)
- Хаалтад (нэмэлтийн хамгийн урт хэлбэр)
- Тодотгол нэмж (жишээлбэл: Speyer, 'the city of Speyer, in West Germany)

2-рт, хуудасны доор

3-рт, бүлгийн төгсгөлд

4-рт номын төгсгөлд тэмдэглэл, эсвэл, тайлбар хэлбэрээр байна” гэжээ.

Нанжиний Их сургуулийн Профессор Юань “Үг нэмэх болон гээх аргууд нь дүрмийг зөв гаргахын тулд, утга санааг нь илүү ойлгомжтой болгохын тулд, эсвэл илэрхийллийг илүү уугуул болгохын үүднээс хэрэглэгддэг” хэмээн “Adding or Omitting Words, Phrases, Clauses” хэмээх дүрс бичлэг дээрээ өгүүлжээ. Мөн тэрээр “Заримдаа бид орчуулгыг зорилтот хэлний илэрхийлэлд нийцүүлэх эсвэл риторик буюу уран хэллэгийн зорилгоор нэмэлтүүд хийдэг” гэсэн байна.

Манай орчуулгын эрдэмтэд мөн орчуулгуудад тодорхой хэмжээний хувиргалууд хийгддэг талаар өгүүлсэн байдаг. Д. Дашдаваа (2010:193) “Д. Нацагдоржийн орчуулгад аливаа орчуулгад өргөн хэрэглэдэг үг нэмэх, орхих, байр солих, орлуулах зэрэг өөрчлөлтүүд элбэг үзэгдэнэ. Тийм өөрчлөлт /трансформаци/ орчуулгад гарахыг орчуулгын онолд зүй ёсны үзэгдэл гэж үздэг” гэжээ. Мөн тус номын 192-р талд “Лошадь у жены что-то заупрямилась, она испугалась, отдала мне поводья и пошла пешком. Эхнэрийн морь эрхчихсэнд айн над цулбуураа өгч хөтөлгөн, өөрөө гэрийн зүг явган одов – Энд утга санааг тод томруунаар гаргах зорилгоор хөтөлгөн, гэрийн зүг гэсэн үг

нэмсэн байна” хэмээн “Д. Нацагдоржийн орчуулгад анализ хийсэн ажиглалтаас” хэмээн бүтээлдээ дурдсан байна. Мөн “Орчуулах эрдэм 2” (1976:11) -т Монгол хэлний тогтолцоонд хос үг түгээмэл юм. Хос үгийг чадамгай хэрэглэвэл (чих хулга, чимээ анир, хүн амьтан гэх мэт) орчуулгын хэл зөөлөрч, чихнээ аятайхан сонсогддог их сайн талтай байна. Оросоос орчуулсан ном зохиол хэмжээгээрээ жаахан томордог явдал үүнтэй ямар нэг хэмжээгээр холбоотой шиг байна. Үүн дээр орчуулгын нуршаа чанар л нэмэгддэггүй байгаасай” хэмээн С. Галсан онцолжээ.

Дээрх эшлэлүүдээс харахад нэмэх арга бол орчуулгын салшгүй нэг хэрэгсэл бөгөөд зөв зүйтэй хэрэглэж гэмээ нь орчуулгын бүтээл уншигчдадаа хүрч чаддаг байх нь ээ.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй

Судалгааны хэрэглэгдэхүүн нь америкийн зохиолч, антропологич Жак Уэтерфордын “Genghis Khan and the Making of the Modern World” болон орчуулагч Г. Ганболдын орчуулсан “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Эзэн Чингис хаан” номууд дахь монголчуудын амьдрах орчин болон байгалийн байдлыг илэрхийлсэн өгүүлбэрүүд болно. Тус өгүүлбэрүүдийг сонгохдоо монголчуудын амьдрах орчин гэдэг утгаар нь нүүдлийн амьдрал ахуй, соёл, онцлог, шашин шүтлэг тэр бүү хэл хоол хүнс зэрэгтэй холбоотой өгүүлбэрүүд болон газар ус, байгаль орчин, цаг ууртай холбоотой бүхий л өгүүлбэрүүдийг багтаахыг хичээсэн. Дээрх сэдвийн хүрээнд өгүүлбэрүүдийг сонгодгийн учир нь уг орчуулгын бүтээлд эдгээр өгүүлбэрүүд нь монгол хүний хэл ярианд нийцсэн, соёл сэтгэхүйд таарсан бөгөөд уран яруу буусанд оршино.

Судалгаанд эхлээд чанарын дараа нь тоон аргыг ашигласан. Үүнд эх зохиол болон орчуулгын зохиолоос дээрх төрөл зүйлүүдийг агуулсан өгүүлбэрүүдийг ялгаж аваад эдгээр өгүүлбэрүүдэд анализ хийн тодорхой үг, хэллэг, илэрхийллүүд нэмэгдсэн эсэхийг тодруулсан. Үүний дараа нэмэх аргууд нь ямар шалтгаан буюу зорилгоор ашиглагдсан болохыг илрүүлж, судалгааны эцэст нь тоон үзүүлэлтүүдийг харьцуулан харуулсан.

Судалгааны шинэлэг тал

Нэгдүгээрт, тус судалгааны хэрэглэгдэхүүн сүүлийн үеийн орчуулгын бүтээл байгаа нь шинэлэг тал болж байна. Хоёрдугаарт, нэмэх аргыг хэрэглэх болсон үндсэн шалтгаануудыг тодорхойлохыг хичээхийн зэрэгцээ тэдгээрийн харьцааг тоон үзүүлэлтүүдээр гаргасанд оршино.

Судалгааны хэсэг

Энэхүү судалгаа нь дээр дурдсан Южин Найдагийн (1964:231-233) зорилтот хэлний бичвэрийг уншигчдад тохируулан буулгах онолыг илүү дэлгэрүүлэн, Р. Димитриюгийн (2004:165) санал болгосон орчуулгыг хэл шинжлэлийн, прагматикийн, соёлын болон үзэл суртлын хувьд тохируулан буулгах онолыг гол чиглэлээ болгосон.

Ингээд дээр дурдсан номуудын монголчуудын амьдрах орчин болон байгалийн байдлыг илэрхийлсэн өгүүлбэрүүдийн үг хэллэгүүдийг харьцуулан судлахад орчуулагч орчуулгын гээх аргыг дараах хүчин зүйлстэй холбоотойгоор хэрэглэсэн болох нь ажиглагдсан. Үүнд:

- Хэл, яриа болон найруулга зүйн онцлог
- Соёлын онцлог
- Байгаль, газар зүйн онцлог
- Үзэл суртал болон орчуулагчийн сонголт

Мэдээллийн сан маань байгаль орчинтой холбоотой өгүүлбэрүүд байгаатай холбоотойгоор байгаль, газар зүйн ялгаанаас үүдэлтэй нэмэлтүүд ажиглагдсан тул “Байгаль, газар зүйн онцлог” хэмээх хэсгийг нэмж оруулсан. Энэ ангилал нь Р. Димитриюгийн (2004:167) дэвшүүлсэн прагматик тохируулгад багтах “их ач холбогдолгүй соёл, цаг хугацаа, орон зайн зөрүүнээс зайлсхийх” хэмээх дэд ангилалд багтаж байгаа юм.

Дээрх 4-н ангиллыг илүү дэлгэрүүлбэл:

Хэл, яриа болон найруулга зүйн онцлогт тохируулан нэмсэн хэсэгт:

- Монголчуудын ярьж дадсан хэлбэрээр буулгахын тулд үг, хэллэгүүдийг нэмсэн хэсгүүд, тухайлбал,
Нэмэлтийн тохиолдол 19: “and leave the southern part of the country dry, a terrain known as gobi, or to foreigners as the Gobi” буюу “говь хэмээх газар нутаг, гадаадынханд бол Гоби гэгддэг нутгийн өмнөд хэсгийг хуурай үлдээнэ” гэсэн утгатай хэсгийг “говь буюу гаднынхан гоби хэмээдэг нутгийн өмнө талыг гандуу хуурай орхино” хэмээн “гандуу хуурай” гэж хоршоо үгээр буулгажээ.
- Уран зохиолын хэлбэр буюу илүү уран яруу илэрхийлэхийн тулд үг, хэллэгүүдийг нэмсэн хэсгүүд, тухайлбал,
Нэмэлтийн тохиолдол 64: The wind made the new snow dance around the horse’s hooves as we slowly climbed the rocky slope of Burkhan Khaldun - Бурхан Халдун ууланд алгуур авирахад шинэ орсон цас морьдын хөлөөр биднийг тойрон босож бүжиглэх мэт бударна. Үүнд бударна гэсэн үгийг нэмсэн байна.

Соёлын онцлогт тохируулан нэмсэн хэсэгт хэсэгт:

- Соёл хоорондын ялгаатай байдал буюу онцлогоос үүдэлтэй нэмсэн хэсгүүд, тухайлбал, Нэмэлтийн тохиолдол 47: Зөвхөн “wrestling” гэсэн байсныг “хүч үзэн уран мэхийг уралдуулан барилдаж” хэмээн соёлын онцлогтой холбоотойгоор дэлгэрүүлж бичсэн байна. Нэмэлтийн тохиолдол 20: searching for grass буюу өвс хайж гэсэн утгатай хэсгийг шинэ соргог бэлчээр хайж хэмээн буулгасан нь мөн л соёлын онцлогтой холбоотой.

Байгаль, газар зүйн онцлог хэсэгт:

- Дэлхийн өөр өөр өнцөг буланд байгаагаас үүдэлтэй байгаль, газар зүйн талаарх ялгаатай ойлголт, төсөөллүүдтэй холбоотойгоор нэмсэн хэсгүүд, тухайлбал, Нэмэлтийн тохиолдол 16: “beyond the range of the Pacific Ocean’s moisture-bearing winds” буюу “Номхон далайн чийг агуулсан салхины хүрээнээс ангид” гэсэн утгатай хэсгийг “Номхон далайн чийглэг, зөөлөн салхи ч хүрдэггүй ажээ” хэмээн зөөлөн гэсэн тодотголыг нэмсэн байгаа нь монголчууд далайн уур амьсгалын талаар төдийлөн ойлголт байхгүй тул илүү тодорхой болгон нэмсэн хэмээн үзэж байгаа юм.


Үзэл суртал болон орчуулагчийн сонголт хэсэгт:

- Зорилтот хэлний үндэстэнд таалагдахгүй буюу нийтлэг үзэл бодолд нь үл нийцэх илэрхийллүүд болон байгаагаар нь буулгаж болохоор байвч нэмэлт оруулсан хэсгүүдийг багтаасан. Тухайлбал, Нэмэлтийн тохиолдол 21: “with only moderate difficulty, a horse and rider can reach all but a few of the peaks in summer” буюу “зуны цагаар цөөн хэдэн оргилоос бусад бүгдэд нь ердөө дунд зэргийн хүндрэлтэйгээр морь, унаач хоёр хүрч чадна” гэсэн утгатай “цөөн хэдэн оргилоос бусад зуны цагаар хаана нь ч гэсэн морьтой, хөсөг тэрэгтэй хялбархан гарч болно” хэмээн “хөсөг тэрэгтэй” гэсэн хэсгийг нэмснийг орчуулагчийн өөрийн сонголт хэмээн үзэж байгаа юм. Нэмэлтийн тохиолдол 60: “the Mongols stopped” буюу “монголчууд зогссон” гэсэн утгатай хэсгийг “арга буюу зогсоход хүрэв” хэмээн буулгасныг монголчуудын нийтлэг үзэл бодолд нийцүүлэхийн тулд нэмсэн байж болох юм.

Ийнхүү монголчуудын амьдрах орчин болон байгалийн байдлыг илэрхийлсэн өгүүлбэрүүдийг түүж авахад 184 хэсэг болсноос үүнд орчуулагч 76 удаа буюу хувьчилбал 41,3%-д нь нэмэх аргыг хэрэглэсэн байна.

Үүнийг доорх График №1-т харуулав.

График №1



Тус аргыг хэрэглэсэн шалтгаануудаар ангилахад:

- 46 буюу 60% нь хэл, яриа болон найруулга зүйн онцлог,
- 19 буюу 25% нь соёлын онцлог,
- 6 буюу 8% нь байгаль, газар зүйн онцлог,
- 5 буюу 7% нь үзэл суртал болон орчуулагчийн сонголттой холбоотойгоор хэрэглэгдсэн байна. Үүнийг доорх График №2-т харуулав.

График №2



Дүгнэлт

1. Нийт тохиолдлын 60%-д нь хэл яриа ба найруулга зүйн онцлогтой холбоотой нэмэлтүүд хийгдсэн нь орчуулагч уг зохиолыг аль болох монголчуудын хэлж ярьж дадсан үг хэллэгээр буулгах, мөн илүү уран яруу, сонсголонтой болгохыг зорьсонд оршиж байна.

2. Монголчуудын соёлын онцлогт тохируулан буулгахад орчуулагч 19 удаа буюу 25%-д нь нэмэлт хийсэн байна. Харин байгаль, газар зүйн ялгаатай байдлаас үүдэлтэй тогтсон ойлголтуудыг тохируулан буулгахын тулд 6-н удаа буюу 8% нь нэмэлт хийжээ. Үзэл суртал буюу орчуулагчийн сонголт гэдэг хэсэгт маш цөөхөн буюу 5-н удаа нэмэлт үг, хэллэг хэрэглэснээс дийлэнх нь яагаад нэмсэн нь их тодорхойгүй, орчуулагчийн сонголт гэж үзэхээс өөр аргагүй хэсгүүд байлаа.

3. Ингээд дээрх үр дүнгээс үзэхэд, орчуулгад нэмэх арга нь өргөн хэрэглэгдэж болохыг харуулж байна. Мөн энэхүү судалгааны үр дүн нь нэмэх аргыг соёлын зөрүүг тэнцвэржүүлэх гэхээсээ илүүтэй зорилтот хэлний ард түмний өөрийн хэл ярианы онцлогт тохируулан буулгахад түлхүү хэрэглэдэг хэмээх саналыг дэвшүүлж байна.

Ном зүй:

Англи хэлээр

1. Dimitriu, R. (2004). Omission in Translation. Perspectives, 12(3), 163-175. <https://scihub.ru/10.1080/0907676X.2004.9961499>
2. Newmark, P. (1988). A Textbook of Translation. New York: Prentice Hall.
3. Nida, E. (1964). Toward a Science of Translation. E. J. Brill
4. Yao, Y. Adding or Omitting Words, Phrases, Clauses. Nanjing University. <https://www.coursera.org/lecture/translation-in-practice/adding-or-omitting-words-phrases-clauses-OXJf8>

Монгол хэлээр

1. Дашдаваа, Д. (2010) Орчуулгын найруулга зүйн бүтэц-утга зүйн үндэс, Улаанбаатар
- Цэдэв, Д. (1976) Орчуулах эрдэм 2, Улаанбаатар